

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны ... сарын ...-ны өдөр Дугаар ___/___/___ Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.13, Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга (цагдаагийн хурандаа Ж.Буянбат)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй дотоод хэргийн яамны төрийн бичгийн дарга (П.Сайнзориг), Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга (Ж.Эрдэмбилэг), Улсын ерөнхий прокурорын орлогч (төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны А/215,421 дугаар тушаалаар батлагдсан “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”, Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/216/422 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Цогцост шинжилгээ хийх журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ
ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

С.ЧИНЗОРИГ

Х.НЯМБААТАР

Б.ЖАРГАЛСАЙХАН

ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан анагаах ухаан, биологийн холбогдолтой асуудлаар шүүх эмнэлгийн шинжилгээ (цаашид “шинжилгээ” гэх) хийх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Шүүх шинжилгээний байгууллагын шинжээч /цаашид “шинжээч” гэх/ нь шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

1.3. Шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.4. Хүний биед шинжилгээ хийхэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 33.1.2, 33.1.3, 33.1.4, 33.2, 41, 42 дугаар зүйлийг баримтална.

1.5. Цогцост шинжилгээ хийхэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 33.1.1, 33.4, 33.5, 33.6, 33.7, 33.8 дугаар зүйл, Монгол Улсын стандарт MNS5377:2004-ыг баримтална.

1.6. Хэргийн материалд шинжилгээ хийхэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 33.3 дугаар зүйл болон дараах шаардлагыг хангасан байна:

1.6.1. Шүүх шинжилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-д заасан шаардлагыг хангасан байх;

1.6.2. шинжилгээ хийх явцад шаардлагатай гэж үзвэл гарвал шинжээч томилсон шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэж мэргэжилтэн, шинжээчийг нэмэлтээр томилуулах;

1.6.3. шаардлагатай тохиолдолд хүний биед үзлэг хийх, нэмэлт лабораторийн болон багажийн шинжилгээ хийх, шарил шинжлэх зэрэг ажиллагаа хийх ба энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэх.

1.7. Шинжилгээ хийх хугацааг тогтооход Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг баримтална.

1.8. Дараах тохиолдолд шинжилгээг багаар хийж болно.

1.8.1. шинжилгээ нарийн төвөгтэй, шинжлэх ухааны цар хүрээ ихтэй;

1.8.2. эмч, эмнэлгийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой болон эхийн эндэгдлийн үед;

1.8.3. шарил шинжлэх;

1.8.4.ялтан ял эдэлж байх хугацаандаа ялаас чөлөөлөх өвчний жагсаалтад багтсан өвчнөөр өвдөж, ял эдлэх боломжгүй болсон тохиолдолд эрүүл мэндийн байдлыг тогтоох.

1.9.Дахин шинжилгээг ижил мэргэжлийн шинжээчийн багаар хийлгэх тохиолдолд шүүх шинжилгээний байгууллагад ажиллаж буй нэг, түүнээс дээш шинжээчийг багийн бүрэлдэхүүнд оруулах ба өөр байгууллага болон бусад этгээдээр энэ хэлбэрийн шинжилгээг дангаар хийлгэхийг хориглоно.

1.10.Шинжээч тусгай мэдлэгийнхээ хүрээнд шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт гаргах ба бусад анагаах ухааны салбар болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдхүүнтэй хамтарсан дүгнэлт гаргана.

1.11.Шинжээчийн бүрэлдэхүүнийг томилох эрх бүхий этгээдийн томилсон нэр бүхий шинжээч, бусад бүрэлдэхүүнийг шинжилгээ хийхэд оролцуулж болно.

1.12.Шинжилгээ хийж байгаа шинжээчид адил тэгш эрхтэйгаар оролцох бөгөөд санал зөрсөн тохиолдолд дүгнэлтийг тусдаа гаргана.

Хоёр.Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх

2.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан тохиолдолд шүүх эмнэлгийн шинжилгээг хийнэ.

2.2.Гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний үхлийн шалтгаан болон цогцос нь хэдэн настай хүн байсныг тогтооход цогцост хийх гадна үзлэгийг дараах байдлаар хийнэ.

2.2.1.цогцсыг зөөвөрлөх буюу хувцсыг нь тайлахын өмнө цогцосны ерөнхий байдал, сүв тус бүрээс гарсан зүйл, биед хутга, багаж болон бусад гадны биет хатгагдсан, зоогдсон эсэхийг сайтар шалгах;

2.2.2.цогцосны нас, хүйс, урт, жин, биеийн галбир, мах мариа, эрхтний бүрэн бүтэн байдлыг тодорхойлох;

2.2.3.цогцсыг дээрээс доош, урдаас арагш чиглэлээр нэг бүрчлэн үзэж, үсний өнгө, урт, хэлбэр, хоёр нүдний зовхи, хүүхэн хараа, хамрын хэлбэр, уруул, амны салстын өнгө, шүдний бүрэн бүтэн байдал, хоёр чихний дэлбэн, хүзүү, их бие, мөчдийн байдал, өөрчлөлт, түүнчлэн ам, хамар, чихний суваг, шээс, өтгөний сүв тус бүрээс ялгарсан зүйлийг шалгаж, өнгө шинж байдлыг нь тодорхойлон үзлэгийн тэмдэглэлд нарийвчлан тусгах;

2.2.4.цогцосны өөрчлөлт /хөрөлт, хөшилт, хүүрийн толбо, хаталт, ялзрал, саванжилт, занданшилт, намагшилт/ үүссэн эсэхийг тодорхойлох.

2.3.Цогцост илэрсэн гэмтэл, өөрчлөлт тус бүрийг дараах байдлаар тэмдэглэлд тусгана.

2.3.1.гэмтлийн төрөл;

2.3.2.гэмтлийн байрлал /үүнийг гэмтэл биеийн аль хэсэгт байгааг босоо, хэвтээ тэнхлэгийн дагуу анатомийн нэршлээр нь тодорхойлно/-ийг тодорхойлох;

2.3.4.гэмтлийн өнгө /үүнийг арьс, салстын өнгөний хувирлаар, хэрэв үндсэн өнгө биш бол ямар туяа болохыг заах, эсхүл олон улсын өнгө тодорхойлогчийг ашиглан тодорхойлно/-ийг тогтоох;

2.3.5.гэмтлийн хэмжээ /үүнийг алслагдсан цэгүүдийн хооронд перпендикуляр огтлолоор хэмжиж /-г тодорхойлох;

2.3.6.гэмтлийн хэлбэр /үүнийг геометрийн дүрс, нийтлэг төстэй зүйлийн хэлбэрээр/-г тодорхойлох;

2.3.7.шархны төгсгөлүүдийн байрлалыг цагийн зүүний байрлалаар тодорхойлж бичих;

2.3.8.гэмтлийн гадаргуу /үүнийг барзгар, гөлгөр, овгор, хонхор, шүүдэс бохирдолт байгаа эсэхээр/-г тодорхойлох;

2.3.9.гэмтлийн зах ирмэг /үүнийг тэгш, тэгш бус, долгионтсон, шүдэлсэн, зах ирмэгт зулгаралт үүссэн, арьс хууларсан зэрэг/-ийг тодорхойлох.

2.4.Цогцосны нас, хүйс, нас баралтын шалтгаантай холбоотой дараах зүйлийг тодорхойлж, тэмдэглэлд тусгана.

2.4.1.өвчин, эмгэгийн гадаад илрэл, хаван, тууралт, цэврүү, гүвдрүү, судас өргөссөн эсэх;

2.4.2.эмэгтэй хүний тухайд хөх, нөсөө, товчны хэлбэр, хэмжээ, гадна бэлэг эрхтэн, охин хальс, үтрээний амсар, хярзан, хошногоны амсрын байдал, өтгөний сүв, үтрээ, хөхнөөс ялгарсан зүйл;

2.4.3.ураг, нярайн цогцосны тухайд, жин, урт, биеийн галбир, салиа, зунгаг, толгойн хэмжээс, үс, шар үс, гуравдагч зовхи, чих, хамрын мөгөөрсний хэлбэржилт, хавирганы завсар, цээжний хэлбэр, хумсны ургалт, бэлгийн их, бага уруулын байдал, төмсөг хуухнагт буусан эсэх, хүйн байрлал, үрэвслийн цагариг, хүйн таслагдсан үзүүрийн байдал, /усанд дүрж үзэх/ , ихэсийн хэмжээ, жин, хэлтэнгийн тоо, цус хуралт, шохойжилт;

2.4.4.хэн болох нь тодорхойгүй цогцосны тухайд урт, жин, биеийн галбир, мах мариа, нүүрний хэлбэр, төрх, сахал, үсний байдал, мэнгэ, ургацаг, сорви, шивээс, хиймэл эрхтэн, өвчин, эмгэгийн илрэл, өмнө хийгдсэн гоо сайхны болон бие эрхтний хагалгааны сорви, ул мөр зэрэг таньж болох онцлогыг.

2.4.5.мэс заслын шархны байрлал, хэмжээ, өнгөр, шархны ирмэг, мэс заслын утас, оёдлын тоо.

2.5.Цогцос дотор эрхтнийг шинжлэхдээ гавал, цээж, хэвлийн хөндийн эрхтнийг заавал нэг бүрчлэн шинжлэх ба тухайн шинжилгээний онцлогоос хамаарч аль ч хөндийгөөс эхлэн хийж болно.

2.6.Цогцосны цээж, хэвлийн хөндийн агууламж, гялтангийн байдал, гадны биет, эрхтнүүдийн байрлалыг тэмдэглэж, дотор эрхтнүүдийг иж бүрдлээр нь гаргаж араас нь урагш, дээрээс нь доош чиглэлээр эрхтэн бүрийг хамруулан үзлэг хийж эрхтэн тус бүрийн дор дурдсан шинж чанарыг тусгасан тэмдэглэл хөтөлнө.

2.6.1.өнгө (үндсэн, суурь өнгө, туяарлаар ялгах);

2.6.2.хэлбэр;
2.6.3.тогтоц (хатуу, биелэг, зөөлөн, шавархаг, улбагар, хагас шингэн, хийрхэг г.м);

2.6.4.гадаргуу (толигор, барзгар, зангилаажсан, мөхлөгжсөн, жигд бус);
2.6.5.ирмэг (нимгэн, зузаан, мохоо, хурц);
2.6.6.хэмжээ (урт, өргө, зузааныг олон улсын Си системийн нэгжээр);
2.6.7.жин (олон улсын Си системийн нэгжээр);
2.6.8.цуллаг эрхтний цусан хангамж;
2.6.9.хөндийт эрхтний салст бүрхүүл болон дотор ханын байдал;
2.7.10.агууламж, гадны биет;
2.6.11.бүтэц (үе давхарга, дэлбэн, дэлбэнцэр, хэлтэн, хэлтэнцэр);
2.6.12.эмгэг өөрчлөлт;
2.6.13.гэмтэл түүний байрлал, шинж байдал;
2.6.14.яс, үе холбоос, мөчийн шинж байдал, хугарал, гэмтэл.

2.7.Цогцосны хөндийг нээмэгц дотор эрхтэний байрлал болон тухайн хөндийд шингэн, эсхүл гадны биет байгаа эсэхийг сайтар тогтооно. Шаардлагатай үед хийн, агаарын, өөхөн бөглөөдөс илрүүлэх сорил хийнэ. Дайвар хөндийг нээх болон мөчдийг шалгах шаардлага гарвал цогцсыг аль болох ар талаас нь нээж үзнэ.

2.8.Шинжээч дотор эрхтнийг нэг бүрчлэн үзэж шинжлэн, дараах байдлаар нэг бүрчлэн тэмдэглэлд тусгана.

2.8.1.гол судасны агууламж, өргөн, уян чанар, хатуурлын товрууны илрэл, гэмтэл, өөрчлөлт;

2.8.2.бөөрний дээд булчирхайн хэмжээ, давхаргын зааг, гэмтэл, өөрчлөлт;

2.8.3.бөөрний өөхөн эд болон бөөрний хэмжээ, өнгө, гадаргуу, тогтоц, цусан хангамж, тэвшинцэр, шээлүүр, давсагны байдал, шээсний өнгө, хэмжээ, гэмтэл, өөрчлөлт;

2.8.4.улаан хоолойн агууламж, салстын өнгө, судасны өргөсөл, гэмтэл, өөрчлөлт;

2.8.5.хэл, залгиур, төвөнхийн мөгөөрс, ховч ясны гэмтэл, өөрчлөлт;

2.8.6.цагаан мөгөөрсөн ба гуурсан хоолойн агууламж, салстын өнгө, цагираг мөгөөрсний байдал, гэмтэл, өөрчлөлт;

2.8.7.цээж, хэвлийн хөндийн цуллаг эрхтнийг дээрээс доош чиглэлээр үзэж шинжлэх ба эрхтэн тус бүрийн өнгө, хэлбэр, тогтоц /хатуу, биелэг, зөөлөн, улбагар/, гадаргуу /толигор, гялгар, барзгар, овон товон, жигд бус/, ирмэг /хурц, мохоо/, хэмжээ /урт, өргөн, зузаан см-ээр/, жин /гр-аар/, цусан хангамж, бүтэц, эмгэг өөрчлөлт, гэмтлийн шинж, байрлал;

2.8.8.зүрх, үнхэлцэг гадаргуу, эдгээрийн хөндий дэх агууламж, ховдлын ханын зузаан, цусан хангамж, хавхлаасын дэлгэсэн урт, хавхлагын ба хөхлөг булчингийн байдал, титэм судасны хатуурал, сүвний нарийсал, гэмтэл, өөрчлөлт;

2.8.9.ходоод, 12 нугалаа гэдэс, цөсний хүүдий, нарийн ба бүдүүн гэдэсний агууламж, салстын өнгө, атираа нугалаасын байдал, гэмтэл, өөрчлөлт;

2.8.10.голт, уушгины уг, чацархайн тунгалгийн булчирхай, судасны салаалалт;

2.8.11.багана нуруу, нугалам, хавирга, эгэм, өвчүү, аарцаг, дээд, доод мөчдийн ясны гэмтэл, өөрчлөлт;

2.8.12.толгой хуйхны дотор тал, гавлын орой, суурь яс, тархины хатуу ба зөөлөн бүрхүүл, тархины бөмбөлөг, түүний судасжилт, тархины эдийн гэмтэл, өөрчлөлт, ховдлын агууламж, шаардлагатай тохиолдолд гавлын дайвар хөндийн агууламж.

2.9.Цогцосны шинжилгээний дараа эрхтнүүдийг цээж, хэвлийн хөндийд буцаан хийж, битүүлэн оёж цэгцэлнэ. Цогцосны бүрэн бүтэн байдлыг хангах, хөндийнүүдээс шингэн гарахаас сэргийлж цогцосны хөндийнүүдэд чихээс хийж болно. Цогцсыг битүүмжлэн оёсны дараа угааж арчин хуурайшуулж, цогцос хадгалах газарт шилжүүлнэ.

2.10.Шинжээч нь шинжилгээний дээжүүдийг лабораториудаас гаргасан зааврын дагуу авч, холбогдох лабораторид илгээх бичгийн хамт хүргүүлэх ба уг бичигт хэний, аль эрхтэнээс хэзээ, хэдий хэмжээгээр дээж авсан, түүнд ямар төрлийн шинжилгээ хийхийг тэмдэглэж, үхлийн шалтгааныг товч бичнэ.

2.11.Цогцост шаардлагагүй зүслэг хийх, эд, эрхтнийг таслах, авахыг хориглоно.

2.12.Цогцсыг дүрслэл оношилгооны аргаар шинжилж болно.

2.13.Цогцост хийх дүрслэл оношлогооны шинжилгээг дангаар болон цогцосны шинжилгээтэй хавсарч хийж болно.

2.14.Цогцост дүрслэл оношлогооны аргаар шинжилгээ хийсэн бол дүгнэлтийг цогцост шинжилгээ хийсэн дүгнэлтийн адил үнэлнэ.

2.15.Цогцост дүрслэл оношлогооны аргаар шинжилгээг хийхдээ “Рентген оношлогооны төхөөрөмжийн ажиллагаанд чанарын хяналтын хэмжилт хийх арга” Монгол улсын стандарт MNS 5391:2010-г баримтална.

2.16.Шинжилгээг хэргийн материалд хийхдээ холбогдох байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамжийн дагуу хавтаст хэрэгт мэргэжлийн шинжээч хавтаст хэрэгт авагдсан шинжээчдийн акт, дүгнэлт, холбогдох эмнэлгийн бичиг баримт, шинжилгээний материалыг дахин шинжилж, шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн бодит дүгнэлтийг гаргана.

2.17.Шинжээч болон хамтарсан шинжээчдийн бүрэлдхүүн хавтаст хэргийн материалаар дахин шинжилгээ явуулж болно.

2.18.Хэргийн материалыг шижээчийн бүрэлдэхүүн хүлээж авсан өдрөөс эхлэн хугацааг тооцно.

2.19.Хэргийн материалын дүгнэлтийг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11-р зүйл болон шинжилгээ хийх жишиг хугацааг баримтлана.

2.20.Хэргийн материал нь дүгнэлт гаргахад шаардлага хангахгүй, эмнэлгийн баримт материал дутуу бол ирүүлсэн холбогдох шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд буцаан, хугацааг сунгуулна.

2.21.Шинжээчийн бүрэлдхүүнийг сондгой тоогоор томилох бөгөөд урьд нь дүгнэлт гаргасан шинжээчийг оролцуулахыг хориглоно.

2.22.Нэмэлт шинжилгээний дүгнэлт тодорхойгүй, бүрэн бус, шинжилгээ хийлгэж буй асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр дүгнэлт гаргасан шинжээчээр дахин шинжилгээний дүгнэлтийг гаргуулж болно.

2.23.Шинжилгээний хэргийн материалд хийсэн шинжилгээний дүгнэлт дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

2.23.1.удиртгал хэсэгт шинжилгээ явуулж эхэлсэн, дууссан он сар, өдөр, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн хаяг, албан тушаал, овог, нэр, томилсон он сар, өдөр, дүгнэлт гаргаж байгаа шинжээчийн албан тушаал, мэргэжлээрээ ажилласан хугацаа, зэрэг, цол, овог, нэр, тодорхой тохиолдолд шинжилгээний объектын гэрийн хаяг, эрхэлдэг ажил, нас, хүйс, овог, нэр, тухайн хэргийн болсон үйл явцын товч мэдээлэл, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс тавигдсан асуултууд;

2.23.2.шинжилгээний үндэслэл хэсэгт хэргийн материалаас дүгнэлт гаргахад үндэслэл болохуйц баримт материал /шинжээчийн дүгнэлтүүд, эмнэлгийн бичиг баримт, бусад/-ыг ойлгомжтой дэс дараалалтай түүвэр, түүврийн хэргийн материалын хуудасны дугаар, он сар өдөр, шаардлагатай тохиолдолд хэргийн газрын үзлэг, гэрч, хохирогч холбогдогчийн мэдүүлэгийг;

2.23.3.дүгнэлтийн хэсэгт шинжээчийн шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавигдсан асуултын хариулт, дүгнэлтийн шинжлэх ухааны үндэслэл, тайлбар.

2.24.Шинжилгээ хийх явцад тухайн хэрэг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зүйлийг олж тогтоосон бол энэ талаар шинжээч томилох эрх бүхий этгээдээс тавигдсан асуултанд тусгагдаагүй ч дүгнэлтэндээ оруулж болно.

2.25.Шинжээчийн гаргасан дүгнэлтээ 2 хувь үйлдэж гарган гарын үсэг зурж, хувийн тамга, байгууллагын тамгаар давхар баталгаажуулна.

2.26.Хэргийн материалд шинжээчийн дүгнэлт гаргахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд цогцсыг ухаж гарган дахин шинжилгээ хийнэ.

2.27.Шинжилгээгээр шинжээч хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтооход Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар батлагдсан “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам”-ыг баримтлан дүгнэлт гаргана.

2.28.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр хүний нас тогтоох шинжилгээг шинжээч хийнэ.

2.29.Хүний нас тогтоох шинжилгээг дараах тохиолдолд хийнэ.

2.29.1. хэн болох нь тодорхойгүй цогцос шинжлэх;

2.29.2.эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд наснаас хамаарч оногдуулах ял шийтгэлийн асуудлыг шийдвэрлэх;

2.29.3.иргэний болон захиргааны хэрэг, маргааны шийдвэрлэх;

2.29.4.бусад.

2.30.Хүний нас тогтоохдоо бие махбодийн анатоми, физиологийн онцлог, шинж тэмдэг болох биеийн өндөр, жин, толгой, цээж, гуя, бугалганы тойрог, насанд хүрээгүй эмэгтэйн аарцагийн хэмжээс, бэлгийн хоёрдогч шинж тэмдэг, суга, умдагны үсжилт, арьсны үрчлээ, нөсөөжил, уян хатан чанар зэрэг олон шинжийг харгалзан үзнэ.

2.31.Хүний нас тогтоох шинжилгээг бусад шинжилгээний адил шинжилгээний ерөнхий ба тусгай арга болон анагаах ухааны уламжлалт, орчин үеийн аргыг ашиглан, MNS 4621:2008 стандартыг баримтлана.

2.32.Хүний нас тогтооход дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

2.32.1.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж байх;

2.32.2.боломжтой бол нас тогтоож буй хүний цахим үнэмлэх, төрсний гэрчилгээ, гадаад паспорт, жолооны үнэмлэх;

2.32.3.Үндэсний төв архивын газрын лавлагаа;

2.32.4.тухайн хүний намтарын талаар сайн мэдэх нас тогтоолгож буй этгээдээс насаар ах хоёроос доошгүй хүний тодорхойлолт, тайлбар;

2.32.5.насанд хүрээгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, сэтгэцийн талаас өөрчлөлттэй этгээдэд шинжилгээ явуулахад түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн баримт бичиг.

2.33.Хүний нас тогтоох шинжилгээг хийхдээ тухайн этгээдийн насны байдлаас хамаарч дараах үндсэн үзүүлэлтийг тусгах бөгөөд шинжилгээ нь удиртгал, үзлэг, шинжилгээ, дүгнэлтийн хэсгээс бүрдсэн магадлагаа гаргана.

2.33.1.биеийн ерөнхий өсөлт, хөгжилтийн хэмжилзүйн үзүүлэлтүүд /антропометрийн/: биеийн өндөр, жин, толгой, цээж, бүсэлхий, бугалга, шуу, бугуй, гуя, шилбэний тойргийн хэмжээ./лент метрээр/;

2.33.2.шүдлэлт, шүдний тоо, өнгө, хазалтын гадаргуугийн байдал, элэгдэл;

2.33.3.насанд хүрээгүй бол бэлгийн хоёрдогч шинж тэмдэг, суга, умдагны үсжилт, бэлгийн бойжилтын шинж, бэлгийн булчирхайн үйл ажиллагааны үзүүлэлт, сахал, биеийн үсжилт, бэлэг эрхтний байдал, насанд хүрээгүй эмэгтэй хүүхдийн аарцагийн хэмжээс, хөхний хэмжээ, биений юмны мөчлөг, ирэлт;

2.33.4.арьсны өнгө, үрчлээс, түүний байрлал, тоо, гүний байдал;

2.33.5.ясжилтын үзүүлэлт, рентген шинжилгээгээр ясжилтын цэг ба нягт, сийрэгжилт.

2.34.Хүний нас тогтоох шинжилгээний дүгнэлтийг дараах насны хэлбэлзэлтэйгээр гаргана.

2.34.1.нярай хүүхдэд 1-3 хоног;

2.34.2.хөхүүл болон 1 хүртэлх насны хүүхдэд 1-2 сарын;

2.34.3.сургуулийн өмнөх насны хүүхдэд 1-2 жилийн;

2.34.4.өсвөр насны хүүхдэд 2-3 жилийн;

2.34.5.хижээл насны хүмүүст 5 жил хүртэл;

2.34.6.50-иас дээш насны хүмүүст 10 жил хүртэл.

2.35.Шинжээч нь ялтан ял эдэлж байх хугацаандаа ялаас чөлөөлөх өвчний жагсаалтад багтсан өвчнөөр өвдөж, ял эдлэх боломжгүй болсон тохиолдолд эрүүл мэндийн байдлыг тогтоох ажиллагааг прокурорын байгууллагын шийдвэрээр хийнэ.

2.36.Шинжээч Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/152, А/366 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтаар батагдсан “Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалт”-ыг баримтлан дүгнэлт гаргана.

Гурав.Бусад

3.1.Шинжилгээний объектод онош тодруулах зорилгоор эмнэлзүйн лаборатори, хор судлал, биологи, бичил амь судлал, шүүх эд судлал, дүрс оношилгоо, молекул генетик болон бусад шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн шинжилгээг хийж болно.

3.2.Шинжээчийн дүгнэлтэд мэргэжлийн болон орчуулах боломжгүй гадаад нэр томъёог олон улсын нэршлээр хэрэглэж болно. Энэ тохиолдолд утгыг заавал эх хэлээр ойлгомжтой тайлбарлана.

3.3.Нэмэлт болон дахин шинжилгээ хийхдээ өмнө гаргасан дүгнэлтийн шинжилгээний объект ба шинжилсэн явцыг дурдаж, нэмж хийсэн ажиллагааны үр дүнг тусгана.

3.4.Шинжилгээнд тусгай болон төрөлжсөн мэргэшлийн шинжээч, нэмэлт гишүүнээр ажилласан тохиолдолд хөлсийг шинжээч томилсон байгууллага холбогдох журмыг үндэслэн олгоно.

3.5.Шүүх хуралдаанд шинжээчээр оролцсоны хөлсийг Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуульд заасны дагуу олгоно.

3.6.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.